

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



**МОНГОЛ ОРНЫ
ГЕОЭКОЛОГИЙН АСУУДАЛ**

№11 (13)

ЭРХЛЭХ ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч: доктор Б.Батбуян
Нарийн бичгийн дарга: доктор П.Баттулга

Редакторын багийн гишүүд: доктор У.Тунгалаг
доктор Я.Баасандорж
доктор, профессор Д.Даш
доктор Ч.Жавзан
доктор Л.Жанчивдорж
доктор Б.Мэндсайхан
доктор Д.Одонцэцэг
доктор А.Саулегул
доктор А.Хауленбек
доктор Н.Цагаанцоож
доктор Д.Цэндсүрэн

Хэвлэлд бэлтгэсэн: С.Баянбилэг
З.Бямбасүрэн
Ш.Долгормаа
Б.Саранчимэг
Б.Мөнхтөр

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Оюун
Цаасны хэмжээ: 172x245 1/10
Хэвлэлийн хуудас:

“АДМОН ПРИНТ” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ШИНЖ ЧАНАР	5
Тарна, Шилүүт голын загасны судалгаа (Б.Мэндсайхан, Т.Гүррагчаа, А.Хауленбек)	5
Говийн томоохон хотторуудын газар доорх усны судалгаа (Г.Удвалцэцэг, Л.Жанчивдорж, Б.Эрдэнэчимэг, Б.Энхцэцэг, Б.Баттуяа, З.Бямбасүрэн, О.Онон)	12
Туул голын зарим урсацын гидрографыг тэжээлийн эх үүсвэрээр ялгасан үр дунгээс (М.Энхтуяа, Д.Одонцэцэг)	20
Онон голын тул (<i>Hucho taimen, Pallas 1773</i>) загас (П.Цогтсайхан, Б.Мэндсайхан)	26
Туул голын сав газрын судалгаагүй жижиг голуудын усны нөөцийг тодорхойлох, урсацын модулийн тархцаын зураг (Х.Бадарч Д.Одонцэцэг)	33
Улаанбаатар хотын ногоон бус дэх модлог идэшт цохын булгэмдлийн бүтэц (Б.Батчедэр, Н.Цагаанцож, Д.Ганбат)	39
Монгол орны заган ойн тархалтын телев байдал, өөрчлөлт (А.Хауленбек, Т.Энэрэл, Т.Гүррагчаа, Н.Итгэлт, Ж.Буян-Эрдэнэ)	44
Өмнөд говийн бүсийн газрын доорх усны нөөцийн үзүүлгээний асуудалд (М.Ринзаан, З.Бямбасүрэн, О.Онон)	52
Төв Монголын хээрийн бүсийн хайрсан далаавчтан багийн шавжийн судалгааны дунгээс (Н.Цагаанцож, Т.Гүррагчаа)	59
Дорнод говийн цэлөрхег хээрийн бүсийн Тооройн тархалт (<i>Populus diversifolia, Schrenk</i>)-ыг судалсан судалгааны үр дунгээс (Ц.Нанзаддорж, А.Хауленбек, Н.Бумбар, Н.Итгэлт, Т.Гүррагчаа, Б.Сүрэн, О.Азбаяр, Т.Энэрэл)	64
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ӨӨРЧЛӨЛТ, ДИНАМИК, ХАРИЛЦАН ХАМААРАЛ	71
Туул голын усны чанар рекреацийн нөлөөлөх нь (Б.Сэнжим, Т.Энхжаргал)	71
The water quality changes of the Bayantsogt (Ar Janchivlin) rashaan in the Tuul river basin (B.Battuya, T.Jamyansuren, B.Dorjkhant)	77
Экосистемийн үйлчилгээнд Туул голын усны чанарын өөрчлөлт нөлөөлөх нь (Т.Энхжаргал, Д.Одонцэцэг)	86
Factors influencing on land use change in Javkhlanit sown of Selenge aimag (B.Khisigjargal, Ya.Baasandorj, Sh.Dolgomsaa, P.Delgertsetseg, N.Khishigsuren, U.Munguutuu)	93
Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрүүдийн газрын доорх усны мониторингийн судалгаа (З.Бямбасүрэн, Б.Огонтуяа)	97

Дендроклиматическая реконструкция динамики водного стока рек бассейна Селенги (середина XVII – начало XXI вв.) (С.Г.Андреев, Ё.Ж.Гармаев, А.А.Аюрганаев, Б.З.Цыдыпов)	105
Элсэнтасархай дахь суурин судалгааны талбайн ургамлан нэмрэгийн өөрчлөлтийн мониторинг судалгааны үр дүнгээс (Н.Итгэлт, Д.Баясгалан, А.Хауленбек, Т.Энэрэл, Т.Гүррагчаа)	112
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ	122
Хүнцэлийн агууламжийг бууруулах MD технологийн туршилт: Хатанбулаг сумын төвийн усан хангамжийг шийдвэрлэх боломж (Л.Жанчивдорж, Т.Энхжаргал, Б.Оюун-Эрдэнэ, Еулсан Чо)	122
Газрын доройтлыг бууруулах экологийн нехен сэргээлтийн туршилт, судалгааны ажлын зарим үр дүнгээс (Сүхбаатар аймгийн Уулбаан сумын харгана бүхий хазаар евс-халганат булгэмдлийн жишээн дээр) (Д.Цогнамсрай, А.Хауленбек, Б.Цэнгэл)	129
Цөөрөм байгуулах замаар бичил эко орчинг бүрдүүлэх нь (Сэлбэ голын жишээн дээр) (Б.Мөнхтөр, Л.Жанчивдорж)	138
Улаанбаатар хотын ногоон бүсийн шинэсэн ойн үрэлт, үрийн чанарын судалгаа (Б.Удвал, Ц.Дашцэвэг, Д.Хоролгарав, С.Амартувшин)	146
Эрдэнэт хотын ус хангамж, ус зүй (Д.Төмөрсүх, Ч.Жавзан)	150
Богдхан уулын Хүүшийн амны таримал шинэсэн ойн ёсөлтийн судалгаа (Г.Батсайхан, П.Баттулга, Д.Цэндсүрэн)	155
Улаанбаатар хотын ногоон бүсийн ойн байгалийн сэргэн ургалтын явц (П.Баттулга, Ж.Цогтбаатар, Д.Цэндсүрэн)	165
Газарзүйн ялгаатай бүсэд ургуулсан эрлийз улиасны судалгааны дүнгээс (Э.Батдорж, Д.Цэндсүрэн, Х.Билгүүн)	173
Говьсумбэр аймгийн усны чанарын асуудалд (Ч.Жавзан, Г.Удвалшэцэг)	177
Орон нутгийн түвшинд "Lada" аргазуй ашигласан судалгааны үр дүнгээс (Т.Энэрэл, А.Хауленбек, Н.Мандах)	184
Environmental impact of placer gold mining activities on the surface water quality in Mongolia: Zaamar goldfield (D.Gerelt-Od, Ch. Javzan)	193
Дархан хотын хөрсний бохирдлын судалгааны дүнгээс (Р.Дэлгэрцэцэг, Я.Баасандорж, А.Бадам, Ф.Билгүүн)	200
Монгол орны тусгай хамгаалалттай газрууд ба хамгаалалтын захиргаадын орон зайн иновчтой байршилыг үзэлэх нь (Н.Оюунчимэг, О.Алтансүх)	204

ДАРХАН ХОТЫН ХӨРСНИЙ БОХИРДЛЫН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

Р.Дэлгэрцэцэг¹, Я.Баасандорж^{1*}, А.Бадам¹, О.Билгүүн¹, С.Баянбильзэг²

¹ШГУА-ийн Газарзүй-Геоэкологийн хурээлэн, Газрын нөөц, газар ашиглалтын салбар,

²Усны нөөц, ус ашиглалтын салбар

Abstract

We took soil samples from ger district area and industrial area in Darkhan-Uul aimag for determining heavy metals such as Cr, Pb, Cd, Ni, Zn, and Cu. From the results, we concluded that some heavy metals were higher than standard such as Zn is 307.4 mg/kg and Cu was 104.7 mg/kg in the iron industrial soil samples which was higher than MNS 5850:2008. However, in other areas heavy metal amounts were normal or less than maximum tolerance amount.

Түлхүүр үргэ: хөрсний хүнд металлын агууламж.

Оршил

Манай улсад газар ашиглалтын хэлбэр зориулалт нэмэгдсэнтэй холбогдох хот сууриин газрууд шинээр бий болж үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн хүрээ жилээс жилд хурдацтай хөгжлийн, хүн ам олноор төвлөрөхийн хэрээр хүний үйл ажиллагааны нелөөгөөр бий болдог бодирдлын эх үүсвэр байнга нэмэгдэж байгаагаас байгаль орчны бодирдлын тархалт ихээхэн газар авч байна.

Хөрсний хүнд металлын бодирдол нь үйлдвэрлэлийн болон ахуйн хог, тээврийн хэрэгслийн түвш шатакууны хаягдал, цахилгаан станцын болон гэрийн зуух, нам даралтын дутуу шаталттай галлагаанаас үүссэн утас, хорт хаягдал, ашигт малтмалын олборлолт зэрэг олон төрлийн түгээмэл эх үүсвэртэй.

Хөрсний химийн бодирдол түүний дотор хүнд металлын бодирдол нь байгаль орчныг бодирдуулаад зогсохгүй, хүнсний бүтээгдэхүүнээр дамжин хүний эрүүл мэндэд аюул дагуулдаг хүчин зүйл болсныг олон судалгааны дун харуулж байна. Тухайлбал авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгардаг хорт утас нь цэвэр агаарыг бодирдуулж, хүний амьсгал боогдуулаад уушги цоррох, хорт хавдар үүсгэх зэрээр хүний эрхтэн системд нелөөлж эдгэршгүй өвчнеер өвчлүүлж байна.

Аливаа эх үүсвэрээс хөрсөнд нэвтрэч буй хортой, аюултай бодис түүний нэгдлүүд хөрсний сувгуудад шүүгдэн баригдаж, хатуу хэсэгт шингээгдэнэ. Хөрсөнд шүүгдэж шингээгдсэн хорт бодис тэндээ физик, хими, биологийн замаар хувиралт, өөрчлөлтөнд ордог [1].

Хүнд металлын элементүүд нь хөрсөнд шингэж, хурумтлагдахдаа хурдан боловч задраяа удаан явагддаг тул хөрснөөс цэвэрлэгдэхдээ төдий их хугацаа шаарддаг. Хөрсөнд агуулагддаг нүүрстөрөгч нь түүнийг задлах идэвхтэй микроорганизм болон өнгөн үе давхаргад амьдардаг аэроб микроорганизмын дэмжилэгтэйгээр хүнд металлын исэлдүүлэх замаар хөрс өөрийгөө цэвэршуулж чадвартай боловч хөрсөнд шингэж буй хорт бодисын терөл олон, хэмжээ их байгаа тул хөрс хурдан хугацаанд цэвэршиж

^{1*} Судалгааны ажлын удирдагч

чадахгүйгээс бохирдолт их байна.

“Газар ашиглалтын өөрчлөлт, түүнд нелеелех хүчин зүйлийн судалгаа” сэдэвт ажлын хурээнд Дархан хотын хөрснеес дээж авч хүнд металлын бохирдлын түвшний судалгааг хийсэн болно.

Судалгааны аргазүй

Дархан хотын үйлдвэрийн болон гэр хорооллын хөрсний 0-15 см гүнээс нийт 8 цэгээс дээж авч хром-Cr, Хар туталга-Pd, кадми-Cd, никель-Ni, цайр-Zn, зэс-Cu зэрэг хүнд металлын элементийг атомын шингээлтийн спектрофотометрийн аргаар тодорхойлж, шинжилгээний дунг Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдхөд дээд хэмжээ MNS 5850:2008 стандарттай харьцуулан дүгнэлт хийв. Мен хөрсний ялзмагийн агуулалтыг И.В.Тюрины аргаар, TDS, EC, урвалын орчин Thermo Orion 370, хеделгээн фосфор, калий Б.П.Мачигины аргаар, шингээгдсэн калий, магний Трилон-Б аргаар тус тус тодорхойлов.

Судалгааны үр дүн

Хот байгуулж үйлдвэр, үйлчилгээ, соёлын төвүүдийг шинээр бий болгож хүн ажиллаж, амьдрах аятай таатай орчныг бүрдүүлж, дэд бүтцийн болон нийгмийн асуудлыг зөвхөн хэмжээнд шийдвэрлэж өгдгөөрөө дэвшилттэй боловч эрүүл ахуй болон хүрээлэн буй орчны хамгаалалтыг орхигдуулсанар хөрс, ус, агаар биологийн болон химийн бохирдолд өртөж, шинж чанар алдагдах зэргээр серег нелеелел ихсэж байна. Үүний улмаас хүний эрүүл мэндэд үзүүлэх хортой нелеелел нь нийгмийн анхаарлыг татсан хүндрэлтэй асуудал болох төлөвтэй байна.

Хүн амын төвлөрөл нээмэгдэхийн хэрээр тухайн хотын хүрээлэн буй орчны доройтол, бохирдол хяналтнаас гарч хөрс, агаар, ус, амьд организмд аюултай түвшинд хүрч болзошгүй байна.

Хөрс нь экологид хамгийн их үүрэг гүйцэтгэдэг, өндөр ач холбогдолтой биет бөгөөд олон терлийн химийн бодисыг яз бурийн хэмжээгээр агуулсан байгалийн цогц биет юм. Иймд хөрсийг хүнд металлын бохирдлоос хамгаалах нь ус, агаарыг хамгаална гэсэн үг юм.

Хүнд металлын заламж. Монгол орны нутаг дэвсгэр дээрх хөрсенд агуулагдах болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдхөд (хүлцэх) дээд хэмжээг стандартад заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдлод орсон гэж узэн.

Хөрс бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдхөд хэмжээг хүлцэх агууламж, хортой агууламж, аюултай агууламж гэж гурван зэрэглэлд хуваадаг. Хүлцэх агууламжийг хүн ам оршин суудаг суурин газар, хөдөө аж ахуйн эдэлбэр, газар тариалан, бэлчээрийн эдэлбэр газруудад мөрдлөг болгодог [3].

Улаанбаатар, Эрдэнэт, Хархорин зэрэг томоохон хотуудын хөрс хүнд металлын элементээр тодорхой хэмжээнд бохирдсон байгааг судлаачид тогтоосон байна [2, 3, 4, 5].

Харин хөрсенд агуулагдах бохирдуулагч бодисын хэмжээ нь аюултай агууламжаас давсан тохиолдолд хөрсний бохирдлыг саармагжуулах, ухаж зайлцуулах, ашиглалтын үйл ажиллагааг зогсоох, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх хүртэл арга хэмжээ авдаг.

Дархан хотын хөрсний химийн бокирдол буюу ялангуяа хүнд металлын бокирдлыг үйлдвэрийн болон гэр хорооллын хөрснөөс нийт 8 цэгээс 9 ш дээж авч хүнд металлын бодисоор бокирдсоныг MNS 5850:2008 стандарт болон Канад улсын хүнд металлын бокирдлын үзүүлэлттэй харьцуулсан судалгааны ажлын дунгээс энэ өгүүлэлд орууллаа. Дархан хотын зарим үйлдвэрийн газар орчмын хөрсний хүнд металлын үзүүлэлтийг тодорхойлж 1-р хүснэгтэнд үзүүлэв.

**1 дүгээр хүснэгт. Хөрснөнд агуулагдах хүнд металлын
агууламж, бокирдолтын төлөв байдал**

№	Дээж газрын байршилын нэр	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
			Cr	Pb	Cd	Ni	Zn	Cu
1	Дархан нээкий үйлдвэр	0-15	22.4	13.4	0.0	20	80.8	14
2	Дархан нээкий үйлдвэрийн хаягдал усны паг	-	891.5	32.5	0.58	6.4	206.4	230.8
3	Цементний үйлдвэр	0-5	46.4	15.1	0.62	62.6	86.9	23.1
		5-15	17.5	10.8	0.13	34.2	70	15.8
4	Төмөрлөгийн үйлдвэрийн орчим	0-15	36.3	7.7	0.17	21.1	109.8	65.8
5	Төмөрлөгийн үйлдвэрийн үнсний хаягдал цэг	-	39.6	30	0.68	20.4	207.5	130.7
6	Дулааны станц	0-10	27.2	9	0.2	3	77.9	21.1
7	Гэр хороолол	0-10	13.5	6.4	0.23	10.1	48.3	8.9
8	Машин засварын газруудын орчим	0-10	12.1	4.7	0.03	18.5	32	10.9
9	4-р ундны усны худаг орчим	0-10	16.2	8	0.02	53.5	45.6	8.3
Стандарт (MNS 5850 : 2008)			150	100	3	150	300	100
Канад улсын стандарт			64	140	1.4	50	200	63

Хүснэгтээс үзэхэд Монгол улсын стандарт орны хөрснөнд агуулагдах бокирдуулагч бодис, элементуудийн зөвшөөрөгдхөх дээд хэмжээг Канад улсын стандартын үзүүлэлттэй харьцуулахад Монгол улсын хөрсний хүнд металлын агууламжийн хэмжээ Канадынхаас ойролцоогоор 2-3 дахин их байна. Энэ нь манай орны хөрсний бокирдолын хэмжээ тодорхойлох арга аргачлал, багаж хэрэгсэлтэй холбоотойгоор шалгуур үзүүлэлтийг сүл тогтоосон байж болох тул цаашид сайжруулах шаардлагатай.

Дархан хотын зарим үйлдвэрийн орчмын газрын хөрснөнд агуулагдах буй хүнд металлын хэмжээг Монгол улсын стандарттаар хөрснөнд агуулагдах бокирдуулагч бодис, элементуудийн зөвшөөрөгдхөх дээд хэмжээтэй харьцуулан дараах байдлаар үзүүлэв.

Хартугалга (Pb) Судалгааны цэгүүдэд хар тугалга зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс бага байна. Харин Төмөрлөгийн үйлдвэрийн үнсний хаягдал цэг орчмоос авсан дээжинд Pb-30.0 мг/кг байгаа нь бусад цэгтэй харьцуулахад их агууламжтай байна. Хар тугалга нь ясны эдийн гэмтэл, шусан дахь уургийн нийлэгжилтийг saatuuлах, мэдрэлийн систем, бөөрийг хямралд оруулдаг. Эрүүл газрын яг хөрснөнд дунджаар Pb 15 мг байдаг. Төмөрлөгийн ба хар тугалганы үйлдвэр, нүүрсний шаталт үнснээс

гаралтай. Үйлдвэрийн орчимд хар туталгын агууламж кг хөрсөнд заримд бүр 3000 мг-д хурдэг байна.

Кадми (Cd). Судалгааны цэгүүдэд кадмийн агууламж нь зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс бага байна. Төмөрлөгийн үйлдвэрийн үнсний хаягдлын орчмоос авсан дээжинд 0.68 мг/кг байгаа нь бусад цэгүүдийн дээжтэй харьцуулахад кадмийн агууламж арай их байна. Кадми нь 1 гр хөрсөнд дунджаар 0.10 мг кадми агуулагддаг ба түүний хэмжээ 0.5 мг-аас бага байхад хөрсийг их бохирдсон гэж үзэггүй байна. Хөрсний уусмалын pH саармаг буюу сулхан шүлтлэг нехцэлд кадми ба бусад элемент хүнд металлын элемент жирийн шингээгдлтийн хувь єндер байна.

Никель (Ni). Судалгааны цэгүүдэд никелийн агууламж нь зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс бага байна. Дулааны цахилгаан станц, гэр хороололын орчмоос авсан дээжинд никель 3-10.1 мг/кг, Дархан-нэхий үйлдвэр, цементний үйлдвэр, төмөрлөгийн үйлдвэрийн орчим болон төмөрлөгийн үйлдвэрийн үнсний хаягдал орчим, 4-р худаг зэрэг газруудын хөрсний дээжинд никель 18.5-53.5 мг/кг байна.

Хром (Cr). Судалгааны цэгүүдэд хромын агууламж нь дулааны цахилгаан станицын орчимд 27.0 мг/кг, төмөрлөгийн үйлдвэрийн орчим болон үйлдвэрийн үнсний хаягдал цэг орчмоос авсан дээжинд хромын агууламж 36.3-39.6 мг/кг агууламжтай байна. Харин Дархан нэхий үйлдвэрийн орчмын өнгөн хөрсөнд хромын агууламж 22.4 мг/кг байхад тухайн үйлдвэрийн хаягдал усны лагаас авсан дээжинд хромын агууламж 891.5 мг/кг байгаа нь зөвшөөрөгдхөх хэмжээнээс 5 дахин их агууламжтай байна. Хромыг төмөрлөгийн үйлдвэр, арьс ширний үйлдвэрт өргөнөөр хэрэглэдэг бөгөөд үйлдвэрийн хаягдал, цэвэрлэх байгууламжийн лаг зэргээс хөрсөнд жилдээ излээд хром ордог байна.

Цайр (Zn): Цайрын агууламж нь төмөрлөгийн үйлдвэрийн орчимд 109.8 мг/кг, тус үйлдвэрийн хаядлын үнсний хаягдлын цэг орчмоос авсан дээжинд Zn 307.5 мг/кг буюу зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс их байна. Гэр хороолол, 4-р худаг, авто засварын орчмоос авсан дээжинд цайрын агууламж 32-48.3 мг/кг, Дархан нэхий, ДЦС, цементний үйлдвэрийн орчмоос авсан дээжинд 70-80.8 мг/кг буюу зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс бага байна.

Зэс (Cu): Зэсийн агууламж нь төмөрлөгийн үйлдвэрийн үнсний хаягдал цэг орчмын хөрсний дээжинд 130.7 мг/кг буюу зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс их байна. Мөн Дархан-Нэхий үйлдвэрийн орчмоос авсан дээжинд зэсийн агууламж 230.8 мг/кг буюу зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс 1 дахин их байна. Бусад цэгүүдэд зэсийн агууламж зөвшөөрөгдхөх дээд хэмжээнээс бага байлаа.

Бид дээрхи цэгүүдээс авсан дээжинд хөрсний химийн зарим шинж чанарыг тодорхойлсон шинжилгээний дунгэрээр гэр хороолол, 4-р ундын усны худгийн орчмоос авсан хөрсний дээжинд ялзмагийн агууламж нь 2.34-2.53 хувь, хөрсний урвалын орчин pH 7.13-7.26 буюу судавтар шүлтлэг шинжлэхүүний, Дархан нэхий, ДЦС, автомашин засварын газруудын орчмоос авсан дээжинд хөрсний ялзмагийн агууламж 1.12-1.74 хувь, хөрсний урвалын орчин ДЦС орчмын дээжинд pH 7.58 хувь буюу шүлтлэг шинжлэхүүний байхад Дархан нэхий, авто засварын газруудын хөрсөнд pH 6.59-7.11 буюу хүчтэй хүчилэгээс

сулавтар шүлтлэг шинжтэй байна. Харин цементний үйлдвэр, темерлэгийн үйлдвэрийн орчмын хөрсний урвалын орчин pH 8.11-8.23 буюу шүлтлэг шинжтэй болсон байна.

Дүгнэлт

Судалгааны дунгзэр Төмөрлэгийн үйлдвэрийн үнсний хаягдал цэг орчмоос авсан хөрсний дээжинд Zn- 307.4 мг/кг, Cu-104.7 мг/кг, Дархан нэхийн үйлдвэрийн хаягдал лагаас авсан дээжинд хромын агууламж нь 891.5 мг/кг байгаа нь зөвшеөрөгдхөд дээд хэмжээнээс их бохирдолтой байгааг тогтоолоо. Энэ нь үйлдвэрийн хаягдал ус, үнс зэрэгт тавигдак хяналт бага, тухайн орчинд замбараагүй хаягдсанаас үүдэлтэй гэж үзэж байна.

Бусад газруудаас авсан хөрсний дээжинд хүнд элементүүд илэрсэн боловч стандартын зөвшеөрөгдхөд дээд хэмжээнээс бага байна.

Талархал

Энэ судалгааг ШУТСангийн SSA_013/14 дугаартай “Газар ашиглалтын өөрчлөлт түүнд нелөөлех хүчин зүйлийн судалгаа” сэдэвт ажлын хурээнд хийж гүйцэтгэсэн болно. Судалгааг гүйцэтгэхэд туслацаа үзүүлсэн хүрээлэнгийн замжиргаа, Дархан хотын байгаль орчны газар, жолооч Е.Ганболд наарт талархал илэрхийлье.

Ашигласан материал

1. Аваадорж Д., Дагва Ш., 2010. “Байгаль орчинд химийн бодисын нелөөлөл, хөрсний бохирдол”. УБ.
2. Рэнцэндорж Г., Алтанболд Э., Батсүрэн Д., “Хархорин сумын жуулчны бааз орчмын өнгөн хөрсенд хүнд металлын бохирдолыг судалсан дунгзэс” Хүрэл тогоот - 2015., 78 х.
3. Баянбилэг С., Жавзан Ч., Отгонсүрэн А., Эрдэнэцэцэг Ц., “Эрдэнэт хотын хаягдлын нуур орчмын өнгөн хөрсний хүнд металлын судалгааны дунгзэс” Хүрэл тогоот - 2015., 94х.
4. Оюунбат П., Энхменх Б., “Улаанбаатар хотын арьс шир боловсруулах үйлдвэр орчмын хөрсний хүнд металлын бохирдол” Хүрэл тогоот - 2015., 121х.
5. Батхишиг О., “Улаанбаатар хотын хөрсний бохирдол” ШУА-ийн Мэдээ 2013 №1 (205)15-19х.
6. Дархан-Уул аймгийн Дархан хотын байгаль орчин төлөв байдлын нарийвчилсан судалгааны тайлан. 2010. 129х